

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүн хоёулаа амин чухал

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Дараах жишээнүүдийн нэгийг сонгоод, сүнслэг мэдлэг олж авах зарчмуудыг ашиглах нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлагын талаарх 1 Коринт 11:11 дээрх үнэнийг ойлгоход нь хэн нэгэнд хэрхэн тусалж болох талаар бодож үз.

1. Кэлигийн охин дүү Элл сургуулийнх нь хэсэг хөвгүүн эрэгтэй хүмүүс эмэгтэй хүмүүсээс илүү чухал гэж хэлж байхыг сонсов. Элл Кэлигээс, “Би хөвгүүд шиг үнэ цэнтэй биш гэж үү?” гэж асуужээ.
2. Чуулгынх нь хэдэн гишүүн эмэгтэйчүүдийг дорд үзсэн байдлаар ярьж байхыг сонсоод Рийдийн санаа зовов.
3. Нэгэн алдартай кино үзсэнийхээ дараа хэсэг найз эцгийн дүрийн гаргасан хачирхалтай үйлдлийг шоолов. Хэдэн найз эцэг огт хэрэгцээгүй байсан гэдэгтэй санал нийлэхэд нэг найз нь “Аз жаргалтай гэр бүлийг бий болгохын тулд эрэгтэй хүн хэрэггүй гэдэг чинь ийм учиртай юм шүү дээ” гэж хэлжээ.
4. Эстэбан, Клара хоёр ариун сүмд гэрлэхээр төлөвлөж байлаа. Эцэг эх нь тэдэнд ирээдүйн гэр бүлдээ тэд тус бүр ямар ямар үүрэг хариуцлага хүлээх талаар ярилцах нь зүйтэй гэж зөвлөв.

Итгэлээр үйлд

- Та эсвэл уг жишээн дээр гарч буй хүн хөндөгдөж буй асуудалд ямар арга замаар итгэлээр үйлдэж, хариу үйлдэл үзүүлж болох вэ?
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн онцгой, амин чухал үүрэг хариуцлагыг үнэлж дүгнэх нь Есүс Христийг дагахад танд хэрхэн туслах вэ?

Утга санаа, асуултыг мөнхийн талаас нь шинжлэн судлах

- Та үүнтэй адил нөхцөл байдалтай тулгарсан үед тус болж болох Тэнгэрлэг Эцэг, Түүний төлөвлөгөөний талаар юу мэдэх вэ?
- Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс ямар ямар үүрэг хариуцлага үүрдэг вэ?

Тэнгэрээс томилогдсон эх сурвалжаар дамжуулан илүү гүн гүнзгий ойлголттой болохыг эрэлхийлэх

- 1 Коринт 11:11-д заасан үнэнүүдийн талаарх таны ойлголт болон гэрчлэл энэ нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэхэд тань хэрхэн туслах вэ?
- Итгэлээр хариу үйлдэл үзүүлэхэд тань туслах судрууд дээрх эсвэл Сүмийн удирдагчдын өөр бусад ямар сүнслэгээр өдөөгдсөн сургаал байна вэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ